

ЧИНГИСИЙН БӨРТЭ ҮЖИН

С. Отгонжаргал

Монгол Улсын Их Сургууль. Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Түүхийн тэнхим.

E-mail: otgoo@usa.com

Өгүүллийн товч утга: Чингис хаан олон эхнэртэй байсан тухай түүхийн сурвалжуудад тэмдэглэгдэн үлджээ. Тэгвэл Чингисийн хувьд Бөртэ Үжин хэн байваа Чингэсээр овоглох эрх түүнд байна уу? Ерөөс Бөртэ гэж хэн бэ бусад хатадуудаас тэрээр юугаараа ялгарч байсан тухай өгүүлнэ.

Түлхүүр үг: Арьгыг аргадах билгийн ухаан

Өгүүллийг тэрлэгч ХХ зууны монголын улс төрийн түүхийг дагнан судалдаг хийгээд энэ сэдвээс нилээд хол гэдгээ тэмдэглье. Хэдий Чингисийн сэдвээс хол ч гэсэн түүний талаархи судалгаа сурвалжийг сонирхон үздэггүй монгол хүн, түүхч үгүй гэж хэлж болно. Энэ утгаараа үүнээс өмнө Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд "Эвийг олбол дэлхийг эзлэнэ-Чингисийн гүн ухаан" сэдвээр илтгэл, эрдэм шинжилгээний ном эмхтгэлд "Чингисийн шашныг үзэх үзэл буюу Мөнх хөх тэнгэрийн хүчин дор" өдөр тутмын хэвлэлд "Чингисийг маань Еврей болгох нь холгүй боллоо" зэрэг хэд хэдэн өгүүлэл бичиж хэвлүүлж байсан юм. Өгүүлэл, илтгэл бичих явцад тухайн үеийн монгол хатадыг, эмэгтэйчүүдийг Чингис хаан хэрхэн үздэг байсан хийгээд ерөөс Бөртэ Үжин гэж хэн бэ гэсэн асуудал сонирхол татсан юм. Ямарч сэдэв судлаач сонирхогчийн өмнө нээлттэй байх нь тухайн асуудлыг олон талаас нь харах боломжийг олгодгоороо ач холбогдолтой байдаг.

Өгүүллээ "Нууц товчоо", "Алтан товч", Рашид- Ад-Дины "Судрын чуулган"-д түшиглэн бичлээ. Чингис хаан Эр хүнийг "нэгэн сэтгэлт эр хэмээвээс эр бус эрдэнэ. Хоёр сэтгэлт эр хэмээвээс эр бус эхнэр" Эмэгтэй хүнийг "нэгэн сэтгэлт эм хэмээвээс эхнэр бус эр. Хоёр сэтгэлт эм хэмээвээс эм бус албин чөтгөр" хэмээн үздэг байсан нь өдгөө сурвалж судалгааны номнуудад хадгалагдан үлджээ. Чингэж үзвэл Бөртэ Үжин Чингисийн хувьд хэн байваа?

Чингис Бөртэд хязгааргүй хайртай байсан гэвэл бас ч тиймгүй байсан талаар "Нууц товчоо"-ноос мэдэж болно. "Нууц товчоо"-нд "Урьд Бөртэ Үжинийг Тэмүүжин өсөн настай байхдаа үзэж ирсэнээс хойш дахин уулзаагүй билээ. Одоо Тэмүүжин Бэлгүүтэй хоёр Бөртэ үжинийг эрэхээр Хэрлэн мөрөн уруу одов. ... Дэй сэцэн Тэмүүжинийг үзэн маш их баясаж ... Бөртэ үжинийг Тэмүүжинд өгөв." Тэмүүжин Бөртэ Үжиний инжинд ирсэн хар булган дахыг Ван ханд бэлзг болгон барьжээ /1.54/. Түүнээс хойш тэд Хэрлэн мөрний эх Бүрги эрэгт нутаглан байтал нэгэн өглөө эрт үүр цайж байхад Өүлэн эхийн гэрт зарцлагдах Хуагчин эмгэн босож өгүүлрүүн: "Эх, эх үтэр бос. Газар дэлбэрэх мэт чимээ гарч, морины төвөргөөн сонсогдоно. Аймшигт тайчууд айсуй биз. Эх даруй бос" гэв. "... Тэмүүжин нар даруй босоод морьдоо барьж Тэмүүжин, Өүлэн эх, Хасар, Хачиун, Тэмүүгэ отчигин, Бэлгүүтэй, Боорчи, Зэлмэ нар тус бүр нэг морь унаж Тэмүүлүнийг Өүлэн эх өвөртөө дүүрэв. Нэгэн моринд юм ачиж хетлөв. Бөртэ Үжинд морь дутав"/1. 55/ Аюул ирсэн үед Тэмүүжин ах дүү нарынхаа хамт Бурхан халдун ууланд нуугдахаар зугтаж зарц Хуагчин эмгэн Бөртэ Үжин хоёр үлдэж удалгүй тайчууд бус гурван мэргэдийн цэргүүд хүрч ирэн Бөртийг чирж гарган аваад явжээ. Бөртэ Үжинийг мэргэдүүд Чилээдүүгийн дүү Чилэгэр бөхөд өгчээ.

Эцгийн зааж өгсөн эхнэрийг Тэмүүжин хүндэлж байсан нь тодорхой ч хань гэсэн утгаараа бүрэн хүлээж аваагүй байсан нь инжинд ирсэн булган дахы нь хайлласангүй Ван ханд барьж, аюулт дайсан ирэхэд ийн орхин одсоноос мэдэж болно. Мөн мэргэдүүд өөрий нь хайгаад ололгүй буцсаныг Тэмүүжин мэдээд өвчүүгээ дэлдэн залбиран өгүүлэхдээ: "

Бөглүү ойт
Бурхан уул
Бөөсөн чинээ амий минь
Бөөцийлөн аварч
Бөөрийн чинээ амий минь
Бүтэн мэнд үлдээв.
Өшөөт дайснаас
Өршөөн аварч
Өнчин бидний өмөг болсон
Өндөр дээд
Бурхан халдуун чамайг
Өглөө бүр мялааж байя
Өдөр бүр тахиж байя
Үрийн үрд
Үүрд тахиж
Үе тутам

Үргэлж шутье гэж бүсээ хүзүүнд эрих мэт өлгөж, малгайгаа гартаа сэгэлдэрч, гараар өвчүүгээ дарж, наран өөд хандаж, Бурхан халдунд есөнтээ сөгдөж өчил өчин, сацал сацав" гэжээ /1. 58/. Тэмүүжингийн энэ үгсэд Бөртэгийн талаар огт дурдаагүй үлдсэн байдаг. Тэмүүжин удаж төдөлгүй Ван ханд бараалхаж мэргэдүүдийг бут цохилцож Бертэг аврахыг хүсчээ. Ван хан Жамуха хоёр Тэмүүжинд биечлэн тусалсанаар Мэргэдүүдийг бут цохидог. Бөртэ Үжин Тэмүүжинтэй эсэн мэнд уулзаж харих замдаа Жүчиг төрүүлжээ. Судрын чуулганд" Зам нь аюултай байсан болохоор бууж өлгий хийх аргагүй байв. Гурил зууран түүгээр хүүхдийг ороогоод хормойдоо хийж биеий нь гэмтээлгүй аятайхан авч явжээ. Гэнэт цочимог төрсөн учир Жочи гэж нэрлэжээ"/ 2. 63/. Жүчи төрсөн нь Тэмүүжин Бөртэ үжин хоёрын харьцаанд таагүй уур амьсгал бий болгосон байна. Бөртэ үжин анх Тэмүүжинд ирээд ямар байр суурьтай байсан нь дээрхээс тодорхой байгаа юм. Одоо гагц аргыг аргадаж чадах билгийн ухаанаас, цааших бүх юм шалтгаалах байлаа. Эр хүн хэдий агуу хүчирхэг ч гэсэн ухаант эмэгтэйн ааш аягаар аливааг гүйцээж явдаг жамтай. Бөртэ Үжинд энэ их ухаан байгаагүйсэн бол Тэмүүжин хүү, Чингис хаан болж дэлхий ертөнцийг донсолгох байсан болов уу. Арга билиг нэгдвээс бэрх хүчтэнийг эрхэндээ болгохуйя хялбар билээ.

Бөртэ Жүчийг төрүүлээд удалгүй Чингисийн сэтгэлийг татах болж нэг сэтгэлт хэмээн хүндлэгдэх болсон байдаг. Мэргэдийг бут цохисны дараа "Тэмүүжин Жамуха хоёр янаг найртай байж нэгэн жил хагас хамт сууж, нэгэн

өдөр тэр нутгаас нүүе гэлцэж ... нүүв. Тэмүүжин Жамуха хоёр, тэрэгнүүдийн урд явж байтал Жамуха :

Тэмүүжин андаа
Ууланд шахан бууя
Адуучинд гэр болтугай.
Голд шахан бууя
Хоньчин хургачин нарт

Хоол болтугай гэв". /1.71/ Жамухын үгний утгыг сайн ойлгоогүй Тэмүүжин эзжээ очиж хэлэхэд Өүлэн эхийг үг хэлээгүй байхад Бөртэ Үжин "Жамуха анд амархан уйдаг гэдэг билээ. Одоо биднээс уйдах цаг нь болсон биз. Жамуха андын хэлсэн үг биднийг жишээлсэн үг буюу. Бид бүү бууя. Энэ хөдөлсөөр шулуухан Жамухаас хагацаж шөнө турш явъя"/1.72/ гэв. Чингис Бөртэ Үжиний үгийг зөвшөөрч үл буун цааш хөдөлжээ. Үүнээс үзэхүүл Бөртэ Үжиний байр суурь нилээд дээшилж хадам эхийн өмнүүр үг хэлэх эрхтэй байхын дээр Чингис ч түүний үгийг хүндэтгэн сонсох болсон байна. Эрх мэдэл булаацаалсан атаа тэмцлийн шалтгааныг Бөртэ Үжин урьдчилан мэдэж Чингисийн хаан болох гагц зам бол Жамухаас хагацах гэж үзжээ. Бөртэ Үжини шийдвэр зөв байлаа. Энэ үеэс Бөртэ Чингисийн жинхэнэ зөвлөх хайр хүндэтгэлийг нь татсан авааль гэргий гэгдэх болжээ. Жүчийн тухай үг үсэг гаргахыг Чингис хаан чандлан хориглох болсон нь Бөртийн нөлөө яах аргагүй мөн байв. Чингис хаан Хорезм уруу дайталаар мордохын өмнө хаан орыг залгамжлах хүүг тодруулахаар болоход зөвхөн Бөртэ Үжини дервөн хүүг дуудсан байдаг. Хамгийн түрүүнд үг хэлэх эрхийг Жүчид олгосон зэргээс Чингисийн Бөртэг үзэх үзэл илт өөрчлөгдсөн нь тодорхой харагддаг юм. Чингис хөвгүүдээ дуудаад "Хөвүүдийн ах Жүчи мөн. Юу хэлнэ? Чи хэл гэв. Зүчийг үг хэлэхийн урьд Цагаадай өгүүлрүүн: "Зүчийг үг хэл гээд Зүчийг юунд томилох /Хaan болгох С.О/ гэж байна? Энэ мэргэдийн орхидост бид захирагдах гэж үү? гэсэнд Зүчи босоод Цагаадайн энгэрээс шүүрэн байж өгүүлрүүн: "Хaan эцэг намайг гадуурхаж үзээгүй байхад чи намайг яагаад ялгаж байна?" гэж тэр хоёрыг муудалцахад Чингис хаан дуугуй сууж байснаа. Бөртэ Үжинийг өмгөөлж:

Хатан сайхан эхийнхээ
Халуун элгийг хөргөж
Хайрт зүрхийг гомтгож
Тос шиг санааг царцуулж
Сүү шиг сэтгэлийг ээдүүлэх
Чалчаа муу үгийг
Цагаадай чи хэллээ
Бүлээн элэг нэгтэй
Бөртэ хатны хүүхэд биш үү
Халуун элэг нэгтэй
Хамт төрсөн хүүхэд биш үү...
Наран шиг гэгээн ухаант

Навч шиг дэлгэр сэтгэлт

Сайн хатан эхийнхээ

Санааг бүү гомдоо гэв. Мөн "Зүчийг тэгж хэлж яаж болно. Хэвүүдий минь ахмад Зүчи биш үү? Хожим тэгж бүү хэлтүгэй" гэж зарлиг болов. Чингис хаан үүний зэрэгцээ Зүчи буруугүй Бөртэ Ужин ч буруугүй аав нь хүчгүй байснаас хүчтний өмнө сөхөрч явсан юм. Эр хүн хүчтэй байж эхнэрээ хажуудаа авч явдаг юм гэж өөрийгөө буруутгасан байдаг. Чингис Зүчи төрсний бурууг ийнхүү гүн ухаарахад Бөртийн нөлөө мэдээж их байсан нь дамжиггүй. Доктор Ч. Жүгдэр агсан энэ тухай "Чингис эхнэр Бөртийг үүрд өөрийн юм байлгахын тулд, түүнийг хэн хүнд булаалгуулахгүйн тулд өөрөө эрэлхэг хүчтэй байх ёстой гэж боддог байв" /3. 183/ гэж дүгнэсэнтэй бичигч санал нэг байгаа юм. Чингист өнгөрсөн үйлдлийг ийнхүү үнэн зөв гүн гүнзгий Бөртэ Ужин ойлгуулж чадсанаараа Зүчийг хүндлэх хайрлах үзэл Чингист төлөвшиж түүнийг бусад гурван хүүгийн нэгэн адилаар үзэх болсон байна. Чингис хаан Зүчийг зүгээр нэг сэтгэлээрээ хайрласнаар хайраа хязгаарласангүй Зүчийг алтан урагт багтааж, түүний үр удмыг өөрийн үр удам мэт хамгаалан, алдаршуулах нөхцлий нь бүрдүүлж өгсөн байдаг. Бөртэ үжний эр хүн хүчтэй байх ёстой гэсэн аугаа уг Чингист Нэгдсэн Монгол улсыг байгуулах улмаар дэлхийг эзлэх их хүч, ухааныг хайрласан ч байж болох юм.

Чингис хаан наран ургах зүг Солонго улсад аялж очтол, Үнэгэн мөрөн үерлэж эзний бие эн их цэрэг, энтээс саатан суув. Элч илгээв. Солонгуудын Буха цагаан хаан өөрийн Хулан нэрт охиноо өгөн өргөж барс гэрт, Буха Солонго хоёр отог инжтэйгээр онгоцоор авчрав. Тэндээс эзэн Богд Солонгуудын Буха цагаан хаан эхлэн ноёд сайд бүгдээрт ... дуудаж зарлиг болгов. Түүний хойно эзэн Богд Хулан хатан хоёр дэр нэгтгэв /4.114/. Нутаг буцах замд "Богд эзэн зарлиг болов: Бөртгөлжин хатан минь бага цагт учирсан бөлгөө. Нуурийг нь үзэх бэрх. Гэрт орвоос гэр нь чухал болом за. Есөн өрлөгүүдийн минь нэг нь уг барилдаж ирэхүл чухал гэж сананам за гэв. Жалайрын Мухулай, эзний зарлигаар одоод хүрч, Бөртгөлжин хатанд мөргөн суув. Тэндээс хатан ийн зарлиг болгов: Эзэн мэнд буюу. Чи юунд ирэв гэж асуув. Эзэн зарлигаа мэдүүл гэж илгээв"/ 4.116/ гээд Мухулай, Хаан эзэнтэн Хулан хатан лугаа дэр нэгтгэснийг дуулгав. Үүнийг сонсоод Бөртэ үжин хэлсэн нь:

Хатан гэгч хааны гэргий буюу

Хаан гэгч хамгийн эзэн буюу

Харц хүнд гурван татвар эм буй атал

Хаад ноёдыг нэн өгүүлэх юун

Хулс нуурын хун галууны олныг

Хорьж харвах нь эр хүний чадал

Хотол дахины хувь хишигтэн охидыг

Хураан авчирах нь эзний минь эрдэм

Эмнэгийн дээр эмээл тохох хийгээд

Эмийн дээр эм авнаа гэгч

Эртнээс үүрд тогтсон хэрэг.

Үүнд ямар харших газар байх вэ /3.184/ гэж хэлж Чингисийн санааг амрааж, улам бишруулэн хүндлүүлэх алхам хийсэн байдаг. Бөртэ Үжинийг "Нууц товчоо"-нд "наран шиг гэгээн ухаант, навч шиг дэлгэр сэтгэлт" хэмээн дэмийн хоосон бичихгүй нь лавтай.

Тулуйн ач Хасан хааны төрийн сайдаар ажиллаж байсан Рашид-Ад-Дины XIII дугаар зууны сүүлчээр бичсэн "Судрын чуулганд" Чингис хаан таван зуу орчим эхнэр ба татвар эмстэй байлаа. Тэднийг тус бүрийг нь янз бүрийн аймгаас авсан байв. Заримыг нь монгол заншил ёсоор сүй тавьж авсан авааль гэргий байсан боловч олонхийг нь босгон авсан буюу олон улс аймгийг эзлэн авах үедээ булаан авсан байдаг байв. Гэвч их хатан гэгдэж хүндлэгддэг нь тав байсан. Тэднийг дор эрэмбээр нь дурьдвал: "анхны эхнэр Бөртэ Үжин Хонгирад аймгийн зонхилогч Дэй ноёны охин билээ. Тэрбээр бүх хатадын дотроос хамгийн ахмад мөн хүндтэй нь бөгөөд тус бүрдээ гойд их нэр хүндтэй ахмад хөвгүүн ба таван охины эх билээ. ... Хоёрдахь хатан нь Хулан, гурав дахь хатан нь Есүй, дөрөвдэх эхнэр нь Гүнж хатан, тав дахь нь Еселүн ... Чингис хааны хатадын дотроос нөлөө бүхий нь эдгээр юм" гэжээ. Үүнээс үзэхүл Бөртэ үжинд Чингисийн Бөртэ гэж овголуулахад ямар их бэрхшээл саад байсныг мэдэж болох юм. Ухаан тэгш, үзэсгэлэн төгөлдөр залуу хатадаас Бөртэ ердөө л ухаанаараа л ялгагдах гагц боломж байсныг тэрээр сайтар ухаарч байлаа. Тэрээр Чингис хааны Зөвлөх байхын зэрэгцээ түүний орыг залгамжлаж чадахуйц тэгш сайхан хан хөвгүүдийг өсгөн хүмүүжүүлж байлаа. Бөртэгийн нэр хүндийг түүний өсгөж буй хүүхдүүдийнх нь хүмүүжил, ухаан, эрдэм чадал өндөрт байлгаж чадахыг тэрээр сайтар ухаарч байв.

Чингис Хөхчу бөөд өндөр итгэл хүлээлгэж дээд тэнгэртэй шууд харьцан хүмүүсийн дотоод далд санааг хаанд тусгайлан мэдээлж байх болон төрийнхөө шашны хэргийг ерөнхийлөн хамаарах хязгааргүй эрхийг олгожээ. Удаж төдөлгүй Хөхчу бөөд шашных нь хязгааргүй эрх бага мэт санагдах болж төрийн хэрэгт нөлөө бүхий болохыг эрмэлзэж хаанаас далдуур шашныг ашиглан хүн олныг өөртөө татаж эхлэв. (3.232) Есөн хэлтэн /хамаг/ улс, Тив тэнгэрт хуралдан очсон ба Чингис хааны агтны хороноос ч олон хүн түүнд очиж захирагдav. Хөхчу Бөө Чингис Хасар хоёрын хооронд яс хаяж, дүү Отчигинг нь ах дүү нартайгаа нийлэн доромжилжээ. Хөхчу бөөгийн энэхүү үйлдлүүдийг Чингис тэвчээртэй ажиглаж, оюун ухаандаа дахин дахин тунгаасны эцэст түүний ууцыг хугалаж үгүй хийх ял оноосон юм. Чингис хаан төрд хоёр толгой байх аваас төр мөхөхийн үндэс хэмээн үзэж Тив Тэнгэрийг яагаад Чингис орлож болохгүй гэж? гэсэн хэний ч санаанд үл буух шийдэл гаргасан байдаг. Тэртээ XIII зуунд тэнгэр газрыг холбогч агуу том зайранг үгүй хийх зоригтон Чингисээс өөр байсан болов уу гэж бичигч өөрийнхөө өмнөх өгүүлэлд дурьдаж Чингисийн ухааны эрх чөлөөтэйг гайхаж байсан. Чингисээс энэ агуу ухаан гарах эх үндэсийг хэн тавьж өгвөө гэсэн асуулт өөрийн эрхгүй гарч ирж байна. "Нууц Товчоо"-г сөхөнгөө. Отчигин ноён Тив Тэнгэрт доромжуулсны дараа Чингис ах дээрээ очиж байдлыг уйлан байж хэлдэг. Чингис хааныг уг хэлэхийн өмнө Бөртэ Үжин, орон дотроос өндийн сууж хөнжлийн захаар өвчүүгээ бүрхэж өгүүлрүүн: Тэд хонхтон нар /Хөхчу Бөөгийнх С.О/ яасан хэцүү хүмүүс билээ? Урьд Хасарыг бүслэн жанчсан. Одоо бас энэ Отчигиных яагаад хойноосоо сөгдүүлэв? Чамайг бэлхэн амьд байхад энэ ямар ёс вэ? Ойн нарс мэт олон сайхан дүү нарыг чинь ингэж дарлаж байна.

Үүнээс хойш тэд
Үүл мэт биеийг чинь
Үгүй болж одвол

Үлдсэн их улсыг чинь
Үр хүүхдээр чинь мэдүүлэх үү?
Сүүлийн цагт тэд
Сүлд гэгээн биеийг чинь
Сүүдэр болж одвол
Сүрэг их улсы чинь
Сүйтгэхэд хүрэх биш үү.
Өндөр уулын нарс мэт
Өнөр сайхан дүү нарыг чинь
Өшин дарлагч тэд
Өсөж божиж амжаагүй
Өчүүхэн хэдэн хүүхдүүдэд чинь
Өргөн улсыг мэдүүлэхгүй

Ясан хэцүү хонхотан нар билээ? Дүү нараа ингэж дарлахыг үзсээр байгаад зүгээр өнгөрүүлэх үү, чи? Гээд Бөртэ Ужин нулимс цувруулав. Бөртэ Ужиний энэ үгийг сонсоод Чингис хаан Отчигинд өгүүлрүүн: “Дэв Тэнгэр одоо ирнэ. Өшөөгөө ав гэв.”/1,214/ Ийнхүү Чингис хаан Хөхчуу бөөг цаазлаж төрөө аврахын зэрэгцээ тэнгэр газрыг хслбогч нь Чингис байх ёстой гэж Мөнх Хөх Тэнгэр зарлиг буулгалаа хэмээн албат ардууддаа итгүүлэн үнэмшүүлж амьд бурхан мэт шүтүүлж чадсан нь Бөртэ Ужини нөлөө байжуу гэмээр байдаг. Бөртийн энэ үгнээс түүний төрийг үзэх үзлийг давхар тодруулж болмоор санагддаг. “Үлдсэн их улсыг чинь, үр хүүхдэд чинь мэдүүлэх үү? Сүрэг их улсыг чинь, сүйтгэхэд хүрэх биш үү. Өчүүхэн хэдэн хүүхдүүдэд чинь, өргөн улсыг чинь мэдүүлэхгүй” гэснээс үзвэл Бөртэ Ужин төрд нэг толгой байхыг ихээхэн чухалчилж байжээ. Мөн Чингисийн төрийг үзэх зэлтэй түүний үзэл давхаж байгаа нь сонирхол татах байгаа юм. Нөгөө талаар Чингисийн байгуулсан төрийг хэн залгамжлан авах талаар эртнээс сэтгэл тавьж гадны, өөр ургийн хүний мэдэлд очихоос ихээхэн болгоомжилж байсныг мэдэж болох юм. Энэ утгаараа ч тэрээр хан хөвгүүдийг эртнээс бэлдэж хүмүүжүүлж байсны үрээр Бөртэ хатны хөвгүүд Чингис хааныг үгүй болсны дараа ч алдаршуулж, энэ л хөвгүүд Чингисийг 200 жил “амьдралсан байна. Үнэхээр ч Бөртийн дөрвөн хөвгүүд, үр удам Чингисийн аян дайныг нэр төртэй үргэлжлүүлж тэдний дэлхийг эзлэхээр хийж байсан аян дайн нь Чингисийн нэрэн дор л бичигдэж байв. Батын хийж буй аян дайныг Европын орнуудад “Чингис ирж явна” гэж бие биенээ айлган сүрдүүлж байв. Бөртийн хөвгүүд хэн байв аа?

Бөртийн “энэ дөрвөн хөвүүн нь ухаантай эрхэмсэг, сайхан чанартай, төгс, эрэлхэг бөгөөд зоригтой нь эцэгтээ, цэрэгтээ, түмэн олондоо үнэлэгдсэн билээ. Чингис хааны төрд тэд дөрвөн гол багана нь мэтээр зүтгэж явсан ажгуу. Тэдний тус бүрд нь төр улсыг тэрбээр Чингис С.О/ байгуулж бий болгож өгсөн бөгөөд мөн тэднийг дөрвөн “хүлэг” гэдэг байв. Үлэху гэдэг нь бусдаасаа гойд ялгаран цойлон гарсан түрүүлэн явдаг шигшмэл хүн, морь зэргийг хэлдэг ажгуу”/2. 221/. Кипчакийн бүх эзэнтэн хан хөвүүн нь Бөртэ Ужиний ууган хүү Зүчийн удмаас гаралтай байлаа гэж Рашид-Ад-Дин бахархан бичсэн байдаг. Туркестанаас Аму дарья мөрний адаг хүртлэх нутгийг Цагадайн удам захирч байсан бол гуравдугаар хөвгүүн Өгөөдэй нь Чингис хааныг залгамжлан их хаан сууж, арван гурван жил төр барьжээ. Түүний хүү Гүюг ч их хааны оронд сууж байв. Дөрөвдүгээр хөвгүүн Тулуй хаан эцэгтээ ихэд хүндлэгддэг нэгэн байжээ. Түүнийг Чингис хаан жинхэнэ Нөхөр гэж үнэлдэг байв. Энх тайван цагт ч дайн тулааны үед ч тэрээр эцгийнхээ дэргэдээс салдаггүй жинхэнэ түшиг тулгуур нь болж явдаг байв. Тулуйн үр удмаас монголын нэр цуутай хаадууд болох Мөнх, Хубилай, Хулагу, Аригбух, Төмөр, Хасан зэрэг хаадууд төрж гарчээ. Үнэхээр ч

дэлхийн түүхэнд бичигдэн үлдсэн хүчирхэг эзэмшил улсуудыг Бөртийн хөвгүүд үр удам нь байгуулсан юм. Зүчи, Цагаадай, Өгөөдэй, Тулуй нар ингэж алдарших эх үндэсийг эх Бөртэ Үжин тавьж өгсөн юм. Чингис хааныг олон хатадтай байсныг дээр дурьдсан билээ. Гэтэл яагаад заавал гагц Бөртийн дөрвөн хөвгүүн алтан ургад орж бусад хатадынх нь үр сад Чингисийн удам атал алтан ургад багтсангүй вэ? Их хуралдай хурахад Бөртийн дөрвөн хүү бүрэн оролцсон бол Хуралдай хэмээн тооцох, тал нь ирээгүй бол Хуралдай гэж тооцохгүй тухай Чингисийн их засаг хуульд заасан байдаг. Энэ утгаараа ч Монголын түүхэнд Чингис, Өгөөдэй, Гүюг, Мөнх нарыг их хаанд тооцож алтан ургийнхан бүрэн оролцоогүй Их Хуралдайгаар хаан ширээнд залагдсан Хубилай сэцэн хааныг их хаан хэмээн үздэггүйн учир энд байдаг юм. Олон эхнэрүүдийн хүүхдүүдийг Алтан урагт оруулж төрийн төлөө буюу хаан ширээний төлөө эх адаггүй тэмцэл өрнөхөөс Чингисийн болгоомжилсон болгоомжлол Бөртэтэй холбоотой нь тодорхой. Бөртэ Үжини "Үлдсэн их улсыг чинь, үр хүүхдээр чинь мэдүүлэх үү?" гэсэн үг өөрийн дөрвөн хөвгүүнээ цохон хэлж нэхрийнхөө сэтгэлд энэ хэдэн хүүхдүүд чинь чиний залгамжлагчид шүү гэдгийг эртнээс сануулж байсан мэт. Олон эхнэрийн эх адаггүй хүүхдүүдийг Чингис хаан төрдөө оруулсан бол дэлхийг донсолгосон Монголын хүчирхэг төр байх байсан болов уу. Үнэндээ үгүй биз ээ. Ядарч явах үед нь хань болон ирсэн авааль эхнэрийнхээ хүчирхэг хөвгүүдээр төрөө түшүүлсэнээр Чингис хаан ч дэлхийд мандах эхлэлээ тавьсан юм. Үүнд Бөртэ Үжиний нөлөө их байсан бизээ. Дэлхийн суут хүнээр тодорсон аугаа хүнийг аугаа ухаантай хатан өөртөө тогтоож чадах нь тодорхой юм. Дэлхийг донсолгосон аугаа хаан хөвгүүдийг аугаа эх л хүмүүжүүлдэг юм. Чингисийн Хулан, Чингисийн Есүй гэж үр хүүхдий нь бахархан бичсэн нь тун ховор. Тэгвэл яагаад Чингисийн Бөртэ гэж?

1227 онд Тангуд улсыг дайлж яваад Чингис хаан тэнгэрт халив. Түүнийг тэнгэрт халихад "Мунын хөөвөрт хасаг тэрэг булд хүртэл шигдэж таван хүлгээр татаж хөдөлгөн ядаж, гүр их улс зовоход Сөнөдийн Гилүгээтэй баатар өчрүүн:

Хөх тэнгэрээс заяагаар төрсөн
Хүлэг Богд эзэн минь
Хүр их улсаа орхиж одов уу чи
Төвшигтэн байгуулсан улс төр чинь
Төгс занят хатад хөвүүд чинь
Төрсөн их газар ус чинь
Тэмүүжин эзэн чамайг хүлээж байна.
... Халуун амийг чинь алдавч
Хас эрдэнэ мэт биеийг чинь
Хамгаалан авч харья эзэн минь
Хатан Бүртгэлжинд чинь үзүүльье
Хамаг улсад чинь хүргээ"/1.240-241/ гэжээ.

Бөөгийн шашинт монголчууд Мунын хөөвөрт хасаг тэрэг булд хүртэл шигдэж таван хүлгээр татаж хөдөлгөн эс чадахад их эзэн хааныхаа сүнсийг аргадах шийдэл гаргасан байдаг. Чухам юугаар аргадвал их хааны хас эрдэнэ мэт биеийг тээж яваа хасаг тэрэг саадгүй хөдлөх вэ гэдгийг эрхбиш тэд сайтар мэдэж байсан нь тодорхой. Ийм ч учраас Сөнөдийн Гилүгээтэй баатар "Төрсөн их газар ус чинь **Хатан Бүртгэлжин чинь Тэмүүжин** эзэн чамайг хүлээж байна" гэж их эзэн хааныхаа сүнсийг авааль эхнэр Бертугэлжингээр нь аргадсан байдаг. Чингис хааны сэтгэлд бусад хатдаас нь илүү Бөртэ Үжин томоохон байр суурийг эзэлж байсныг "Нууц Товчоон"-ны энэ мөрүүд улам тодруулж байгаа юм.

Чингисийн Бөртэ-Үжин гэж тэрээр Чингисээрээ аугаа их Чингис хаанаар овоглох бүрэн эрхтэй.

